



# ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ, ТАРХАЛТЫН МЭДЭЭ

Хоёр долоо хоног тутмын мэдээ, №23

2017.12.16

**НЭГ. Шувууны томуугийн А хүрээний (H5N1) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

2017 оны 12-р сарын 01-ээс 12-р сарын 16-ны хүртэлх хугацаанд Номхон далайн баруун бүсийн 4 оронд хүний өвчлөлийн **шинэ тохиолдол** бүртгэгдээгүй байна.(Хүснэгт 1)

**ХОЁР. 2003 оноос хойш бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл ба нас баралт:**

2003 оноос 2017 оны 12-р сарын 16-ны хүртэлх хугацаанд дэлхийн 16 улсад шувууны томуугийн А хүрээний H5N1 вирусын **860** тохиолдол бүртгэгдсэнээс **454** (52.7%) нь нас барсан бөгөөд сүүлийн тохиолдол 9-р сарын 26-нд Индонези улсад 1 тохиолдол бүртгэгдэж нас барсан байна. 2003 оноос хойш Номхон далайн баруун бүсийн 4 оронд **238** тохиолдол бүртгэгдсэнээс **134** (56%) нь нас барсан байна. Камбожи улсад нас баралтын түвшин хамгийн өндөр (66%; 37/56) байна.

**ГУРАВ. Шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

2017 оны 12-р сарын 01-ээс 12-р сарын 16-ны хүртэлх хугацаанд шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусын хүний өвчлөлийн **шинэ тохиолдол** бүртгэгдээгүй байна.

2014 оны 5-р сараас хойш БНХАУ-д лабораториор батлагдсан нийт **16** тохиолдоос **6** (37.5%) нь нас барсан байна.

**Хүснэгт 1. ДЭМБ-д мэдээлэгдсэн томуугийн А (H5N1) вирусын халдвартын хүний өвчлөл, нас баралт, бодит тоогоор, 2003 – 2017.12.16**

Улс	2003-2011		2012		2013		2014		2015		2016		2017		Нийт	
	T	H	T	H	T	H	T	H	T	H	T	H	T	H	T	H
Камбожи	18	16	3	3	26	14	9	4	0	0	0	0	0	0	<b>56</b>	<b>37</b>
Хятад	41	27	2	1	2	2	2	0	6	1	0	0	0	0	<b>53</b>	<b>31</b>
Лаос	2	2	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	<b>2</b>	<b>2</b>
Вьетнам	119	59	4	2	2	1	2	2	0	0	0	0	0	0	<b>127</b>	<b>64</b>
Нийт	180	104	9	6	30	16	13	6	6	1	0	0	0	0	<b>238</b>	<b>134</b>

**ДӨРӨВ. Шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

2017 оны 12-р сарын 01-ээс 12-р сарын 16-ны хүртэлх хугацаанд шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусын хүний өвчлөлийн (1) шинэ тохиолдол БНХАУ-д бүртгэгдсэн талаар Хятадын үндэсний эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн хорооноос мэдэгдсэн байна.

Уг тохиолдол нь 64 настай эрэгтэй, Юннань мужад оршин суудаг. Өвчний шинж тэмдэг 2017 оны 11-р сарын 21-нд эхэлсэн бөгөөд энэ нь Дэлхий даяр А хүрээний (H7N9) вирусын 6 дахь дэгдэлтийн анхны тохиолдол юм.

2013 оноос хойш шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусын хүний өвчлөлийн нийт **1565** тохиолдол лабораториор батлагдсан.

**ТАВ. Шувууны томуугийн А хүрээний (H5N1) вирусын шувууны өвчлөлийн мэдээлэл:**

**2017.12.01 - 12.16**

Тив	Улс	Өртөмхий	Өвчтэй	Үхсэн	Устгасан	Нядалсан	Өртөмхий зүйл
Ази	Камбожи	1027	0	500	0	0	Тэжээвэр тахиа, нугас, галуу, цацагт хяруул
	Индонези	0	2169	2169	0	0	Тэжээвэр тахиа, нугас
	Нийт	1027	2169	2669	0	0	-

*Албан ёсны эх сурвалж:*

- [http://www.who.int/influenza/human\\_animal\\_interface/H5N1\\_cumulative\\_table\\_archives/en/index.html](http://www.who.int/influenza/human_animal_interface/H5N1_cumulative_table_archives/en/index.html)
- [http://www.who.int/influenza/human\\_animal\\_interface/EN\\_GIP\\_20140727CumulativeNumber\\_H5N1cases.pdf](http://www.who.int/influenza/human_animal_interface/EN_GIP_20140727CumulativeNumber_H5N1cases.pdf)
- [http://www.wpro.who.int/outbreaks\\_emergencies/H7N9/en/index.html](http://www.wpro.who.int/outbreaks_emergencies/H7N9/en/index.html)
- [http://www.who.int/influenza/human\\_animal\\_interface/influenza\\_h7n9/en/index.m](http://www.who.int/influenza/human_animal_interface/influenza_h7n9/en/index.m)
- [http://www.wpro.who.int/emerging\\_diseases/aiweekly\\_465\\_09jan2015.pdf?ua=1](http://www.wpro.who.int/emerging_diseases/aiweekly_465_09jan2015.pdf?ua=1)
- <http://empres-i.fao.org/eipws3g/#h=0>

**ЗӨСҮТ**

**ЭУББТСТ**

**ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧИН ХАРИУЦСАН БАГ**